

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын эдийн засаг 2023 онд 7 хувь орчим өссөн. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл тэр дотроо нүүрсний экспорт огцом өсөж, хувийн хэрэглээ сэргэж байгаа, мөн төсвийн зардал тэлсэн зэрэг үзүүлэлтүүд нь эдийн засгийн өсөлтийг голлон тодорхойлжээ. Өнгөрсөн жил Монгол улс 70 сая нүүрс экспортолж бараг 9 тэрбум ам.доллар нүүрснээс олсон нь эдийн засгийн өсөлтийг бий болгосон байна.

Гэвч эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй томоохон эрсдэлүүд байсаар байна. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх, нүүрсний оффтейк гэрээнүүдээс шалтгаалан уул уурхайн экспортын орлого багасах, сонгуультай холбоотой төсөв улам тэлэх, Ойрх Дорнод дахь geopolitikiйн хурцадмал байдлаас шалтгаалж газрын тосны үнэ өсөх зэрэг хүчин зүйлүүд инфляцын дарамтыг бий болгож болзошгүй байна.

Уул уурхайн түүхий эдийн экспорт огцом тэлснээр Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал сайжирч байна. Энэхүү эерэг нөхцөл байдлыг цаашдаа тогтвортой хадгалахад эдийн засгийг төрөлжүүлэх, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд тэсвэртэй байдлыг бэхжүүлэхд чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал юм.

Инфляцын дарамтыг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд төсвийн тэлэлтийг сааруулж, эдийн засагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаад хөрөнгийн зах зээлд Монгол Улсад итгэх итгэлийг бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнгөрсөн жил нүүрсний борлуулалтаас шалтгаалж эдийн засаг өссөн хэдий ч дараах сөрөг үр дүн оршсоор байна. Үүнд:

1. Манай эдийн засаг түүхий эдээс маш өндөр буюу бараг 94% хамааралтай болсон. Ийм өндөр хамааралтай болсон нөхцөлд бусад улсад байдагтай адилгүй эдийн засгийн савлагaa маш өндөр боллоо.

2. Улсын төсөв ДНБ-ний 39 хувьд хүрснээр хувийн хэвшлийн орон зай улам бүр хумигдаж, уул уурхайн борлуулалтаас хамааралтай боллоо.

3. Татварын ерөнхий газрын статистик мэдээгээр Монгол Улсад 2022 оны эцсийн байдлаар бүртгэлтэй 218,965 аж ахуйн нэгжээс 155.450 нь татварын тайлангаа ирүүлсний 70.561 нь Х тайлан ирүүлжээ. Өөрөөр хэлбэл, 134.076 аж ахуй нэгж хаалгаа барьжээ.

4. 2022 оны байдлаар манай улсын нийт хүн амын 914 мянга нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна.

Энэ бүхэн үндэсний үйлдвэрлэлээ бүх талаар дэмжихийг анхааруулсан тоон үзүүлэлт юм. Зөвхөн хуулийн нэг заалт өөрчилснөөр гадаадын хөрөнгө оруулалтыг

татах, үндэсний үйлдвэрлэлээ сэргээх, ажлын байр нэмэх, иргэдийн орлого нэмэгдүүлэх боломжийг алдах ёсгүй юм.

Иймд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах санаачилга гаргаж байна. Хуулийн үндсэн бүтцийг хөндөлгүй хэвээр үлдээх тул Үзэл баримтлалын ноцтой өөрчлөлт гарагчийг ажлын байр болон татварын бааз суурь нэмэгдэж төсвийн орлого нэмэгдэх юм.

**Хоёр. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 зүйлтэй байхаар тусгагдсан ба 1 дүгээр зүйлд, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дахь заалтыг "Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд ажлын байрыг шинээр бий болгох замаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа болон оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 5 жилийн хугацаанд хуваан тэнцүү хэмжээтэй хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно" гэж өөрчлөх бол 2 дугаар зүйлд, 40 дугаар зүйлийн 40.8 дахь хэсгийг "40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн" 38.1.20, 38.1.22, 40.2, 40.4, 40.5, 40.6-д заасныг хэрэгжүүлэх журам" гэснийг "38.1.22, 40.2, 40.4, 40.5, 40.6, 40.7-д заасныг хэрэгжүүлэх журам, тавигдах шаардлагыг" гэж, мөн зүйлийн 40.7 дахь хэсгийн дугаарыг "40.8" гэж тус тус өөрчилсүгэй" гэсэн заалт нэмж байгаатай холбоотой зүйл заалтын дугаар өөрчлөхөөр тусгана.

**Гурав. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:**

- Хуульд санал болгож буй нэмэлт, өөрчлөлт оруулснаар,
- Ажлын байр нэмэгдэнэ
- Импортыг орлох, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл сэргэнэ.
- Улсын болон орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.
- Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, валютын урсгал эрс сайжирна.
- Мөрийн хөтөлбөр, уриалгууд хэрэгжиж өхөлнэ.
- Эдийн засгийг солонгоруулах боломж бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүгийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байна. Цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох дагалдах хуулийн асуудал байхгүй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**